

# НЭР ТОМЬЁО БОЛОВСРУУЛАХ АЖИЛ: ТОДОРХОЙЛОЛТ БА СТАНДАРТЧИЛЛЫН ТУХАЙ АСУУДАЛ

*О. Мягмарсүрэн, магистр, МУБИС*

**Abstract:** The main purpose of this study (Some aspect of terminology work: Definition and standardization) was to identify concepts of terminology in science and technology field. Especially in energy field. There are almost no definitions of the term in Mongolian. It is essential to develop terminology to analyze its modern aspects. We need terminology standardization to express individual terms in single definitions and understandings of concepts throughout the world. But in most of our professional fields, there is no standard of term translated and interpreted. It is really important to have standards of terms and determine the definitions in Mongolia. As we mentioned, in large-scale scientific literature translation in which many people are involved, inconsistency in the translation of the same terminology is inevitable.

First, this paper carried out a comprehensive analysis to terminology definition inconsistency, finding that most are terminology with same meaning but different concepts and definition.

Second, we put forward a semantic similarity-based calculation method to identify this category of terminology in consistency, selected translation with high frequency of network using Canadian glossary of terms, and carried out unionization.

Finally, evaluate the concept improvement (post-editing) and consistency of terminology definition. In the experimental analysis, 1000-word patent document (English-Mongolian terminology) is selected.

**Түлхүүр үг:** ухагдахуун, систем, тодорхойлолт, стандарт, тэмдэглэгээ

## Удиртгал

1924 оноос эхлэн монгол улсын нэр томьёоны комисс ажиллах үед нэр томьёоны ажил цэгцтэй үр бүтээлтэй байсан билээ. Монголчууд бид шинэ техник технологийг бүтээж үйлдвэрлэдэггүй учраас шууд гадаад нэр томьёог хэрэглэж байна. Бид орчин цагийн шинэ нарийн төвөгтэй ухагдахууныг өөрийн хэл дээр бүрэн гүйцэд ойлгож чадахгүй байгаа төдийгүй 1990 оноос хойш нэр томьёо судлалд дорвитой ахиц харагдахгүй байна. Шинэ нэр томьёо үүсгэх, түүнийг тогтоох, стандартчилах үйл ажиллагааны хурд бодит хэрэгцээ шаардлагаас хоцорч байна. Хэл шинжлэлийн салбар хүртэл нэр томьёогоо цэгцлээгүй байна. Тухайлбал “Applied linguistic” гэдгийг хавсарга хэл шинжлэл, хэрэглээний хэл шинжлэл гэж аль алианаар нь хэрэглэж байна (Зундуйсүрэн, 2013, х.322). Сүүлийн жилүүдэд хэл шинжлэлийн бус салбарын эрдэмтэд, судлаачид, мэргэжилтнүүдийн нэр хөдөлмөр, идэвх санаачилгын ачаар олон тооны нэр томьёоны толь хэвлэгдэн гарч олны хүртээл болж байгаа нь сайшаалтай хэдий ч бид нэр томьёог боловсруулах үндэсний стандартуудыг одоо болтол гаргаагүй тул алдаа мадагтай зүйл олон байгаад тэдгээр толь бичиг зохиогчдыг буруутгах аргагүй.

Орчин цагт инженерийн салбарт төрөл бүрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл гадаадаас орж

ирэх явдал улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд дэлхийн даяарчлалын бодлого, олон улсын нэгдсэн стандарт, хүн нийгмийн харилцааны цоо шинэ ойлголт болох интернэт өдөр тутмын амьдралд нэвтэрч бидний хэрэглэх орчуулга, нэр томьёоны стандартчиллын асуудал чухлаар хөндөгдөх боллоо. Тиймээс аливаа шинжлэх ухааны нэр томьёог дөнгөж нэвтэрч, хэрэглэж хэвшиж эхлэхээс нь л зөв оноон орчуулж, нэг мөр болгох нь чухал юм.

Нэр томьёог “Шинжлэх ухаан, техникийн хэл” гэж нэрлэх нь бий. Шинжлэх ухаан техникийн нэр томьёонд тавьдаг үндсэн шаардлага байдаг. Нэр томьёо аль болох товч, ганц утгатай, ойролцоо утгат үггүй, найруулгын болон сэтгэл хөдлөлийн өнгөгүй, оновчтой, тухайн хэлний үг бүтэх ёсны үүднээс зөв, мөн дуудахад эвтэйхэн, гоозүйн шаардлагад тохирсон байх ёстой гэж онолын үүднээс авч үздэг ба үүнийг нэр томьёоны үндсэн шаардлага гэж нэрлэдэг. Улсын хэмжээнд нэр томьёог нэгтгэн гаргасан шинжлэх ухааны баримт бичиг нь нэр томьёоны толь юм.

1990 оноос хойш одоог хүртэл нийт 70 гаруй нэр томьёоны толь хэвлэгджээ. Зөвхөн 2014 онд гэхэд “Түймрийн менежментийн нэр томьёоны англи, монгол, орос толь”, “Орос, монгол, хятад хэлний төмөр замын нэр томьёоны толь бичиг”,

Г. Мэндхүү нарын “Телевизийн тухай А-Я хүртэл тайлбар толь”, Н. Янжмаа нарын “Анагаахын нэр томъёоны ухагдахууны англи, орос, латин, монгол дэлгэрэнгүй тайлбар толь”, Ч. Зээнямбуу нарын “Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь”, П. Онхуудайн “Анагаах ухааны гадаад нэр томъёоны зурагтай тайлбар толь”, Р. Баттогтох нарын “Барилгын нэр томъёоны толь”, Б. Сайнзаяа нарын “Математикийн англи монгол нэр томъёо, үг хэллэгийн лавлах толь”, Д. Ичинхорлоогийн “Газар тариалангийн нэр томъёоны олон хэлний зурагт толь бичиг” зэрэг нэр томъёоны толь хэвлэгдсэн байна. Эдгээр толь бичигт нэр томъёоны ухагдахууны тайлбар тодорхойлолт байхгүй, нэг нэр томъёог олон янзаар оноосон байна. Харин 2013 онд хэвлэгдсэн Ч. Зундуйсүрэн нарын “Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг (англи, орос, монгол, хятад)” нь нэр томъёог нэг мөр болгож стандартчилахад чухал бүтээл болжээ.

Цаашид нэр томъёоны толь боловсруулж хэвлүүлэх ажлыг журамлах шаардлагатай байгаа бөгөөд хэл шинжлэлийн болон мэргэжлийн салбарын эрдэмтдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний үнэлэлт дүгнэлтэнд үндэслэн толь бичгийг олон нийтийн хүртээл болгон хэвлүүлэх эсэх талаар хяналт тавих хэрэгтэй юм.

Нэр томъёог нэгдмэл болгон жигдлэх асуудлыг:

1. Салбар доторх
2. Салбар хоорондын
3. Улсын доторх
4. Улс хоорондын гэсэн хэдэн үе шаттайгаар авч үзэн хэрэгжүүлбэл зохистой юм.

Туршлагаас үзэхэд ихэнх улс орон эхний гурван шатны эцсийн шат буюу улс хоорондын олон улсын нэр томъёог цэгцлэх, стандартчилах ажилд анхаарлаа хандуулж байна. Манай улсын хэмжээнд нэр томъёог журамлах асуудал салбар дотроо ч жигдрээгүй байгаа нь нэг юм үзэгдэл, ойлголтын нэр олон, ойлгомжгүй болж бусад салбарын нэр томъёотой давхцах, утга ухагдахуун ташаарч, улмаар салбар доторх мэргэжилтэн хоорондоо ойлголцоход бэрхшээл учрах болжээ. Үүнийг шийдвэрлэх гол арга зам нь Олон улсын нэр томъёоны стандартчиллын байгууллага ISO /International Organization for Standardization/, Олон улсын нэр томъёо судлалын хороо ICTUN /International Committee for Unification of Terminological Neologism/-ны стандартчиллын дагуу оновчтой орчуулан Монгол Улсын Үндэсний Стандартаар батлуулан мөрдөх явдал гэж үзэж байна.

### Нэр томъёоны тодорхойлолт ба стандарт

Нэр томъёо нь жирийн үгээс ялгаагүй мэт бидэнд санагдаж болох юм. Учир нь нэр томъёо жирийн бүх үгийн адил тодорхой утгатай, хэлзүйн аятай, мөн л тодорхой үгтэй хамт хэрэглэгддэг. Гэхдээ нэр томъёо шинжлэх ухаан, техникийн тодорхой нэг ухагдахууныг тэмдэглэдгээрээ онцлогтой юм.

Клувер “Техникийн хэл буюу нэр томъёог стандартчилж болох боловч ердийн хэлний үгийг стандартчилж болохгүй” гэсэн байдаг (Клувер, 1989, х.13).

“Нэр томъёо нь тусгай зориулалтын, мэргэжлийн, явцуу, нэг хүрээнд ашигладаг, тусгай мэдлэгийг агуулсан, ганц утгатай шинжлэх ухааны тодорхойлолтой байна” (Болд, 2009, х.45). Нэг нэр томъёо зөвхөн нэг ойлголт ухагдахууныг илэрхийлэх ёстой бөгөөд ижил утга ухагдахуун байх ёсгүй юм (Нахир, 2003, х.8). Гэвч Монгол хэлэнд нэг нэр томъёо нэг ухагдахуун гэсэн зарчим алдагдаж, улмаар нэр томъёог хооронд нь сольж өөр өөрөөр ашиглаж байна.

Нэр томъёо бол тусгай хэлний тусгай судлагдахууны хүрээнд багтах ерөнхий ухагдахууныг илэрхийлэх нэг ба хэд хэдэн үгээс бүрддэг тэмдэглэгээ юм. Энгийн нэр томъёо нь зөвхөн нэг язгуурыг агуулдаг бол хоёр ба түүнээс дээш язгуур агуулдаг нэр томъёог нийлмэл нэр томъёо гэж нэрлэдэг (Сполский, 2004, х.14).

Хэд хэдэн тэмдэглэгээнээс илүү зохистойг тухайн салбарын мэргэжилтнүүд сонгож хэрэглэдэг. Ухагдахууныг тэмдэглэхийн тулд үүсгэсэн шинэ нэр томъёо бол шинэ үгсийн нэг төрөл бөгөөд түүнийг шинэ нэр томъёо гэдэг. Ихэнх тохиолдолд шинэ нэр томъёо нь шинэ ухагдахууныг тэмдэглэдэг бол заримдаа тогтсон ухагдахууныг илэрхийлдэг.

Харин тусгай хэлэнд, ялангуяа шинжлэх ухаан, технологийн салбарт нарийн оновчтой харилцаа шаардлагатай бол нэр томъёогоор дамжуулан ухагдахууныг илэрхийлэхдээ тухайн салбарт нэг нэр томъёо нэг ухагдахуунтай харгалзаж, тухайн ухагдахуун оновчтой нэг нэр томъёогоор тэмдэглэгддэг байвал хамгийн төгс ойлголт болох юм. Гэтэл хэд хэдэн ухагдахуун илэрхийлдэг нэг нэр томъёо, нэг ижил ухагдахууныг илэрхийлдэг хэд хэдэн тэмдэглэгээ байх нь хоёрдмол ойлголтод хүргэдэг.

Дэлхийн олон улс орон олон улсын болон үндэсний хэмжээний шинжлэх ухаан, техник технологийн нэр томъёоны цахим сан бүрдүүлж, улмаар хэдэн сая нэр томъёог олон хэлээр орчуулан байршуулсан байдаг. Тэдгээр нэр томъёоны ихэнх

нь стандартчилагдсан байдаг байна. Учир нь интернэт сүлжээн дэх файл хэлбэрийн нэр томьёог нэг стандартад оруулах, оноон жигдлэхэд хялбар төдийгүй тэдгээр стандартчилагдсан нэр томьёог олон нийтэд хэрэглэж хэвшихэд өргөн боломж бүрдэх юм.

Олон улсын түвшинд нэр томьёог тогтоохдоо ухагдахууны холбоо хамаарлыг нарийн авч үздэг. Хүмүүсийн харилцаанд ертөнц дээрх объект бүр ялгагдах нэртэй байдаггүй. Үүний оронд ажиглалт хийх, ухагдахуунчилах хэмээн нэрлэгдэх хийсвэр процессоор дамжуулан объектуудыг ангилдаг. Тэдгээр нь ухагдахуун хэмээх мэдлэгийн нэгжүүдтэй тохирч байдаг. Харин ухагдахуунууд нь харилцааны янз бүрийн хэлбэрүүдэд (объект-ухагдахуун- харилцаа) илэрч гардаг.

### Нэр томьёоны тодорхойлолтыг:

1. Дэлгэрэнгүй тодорхойлолт (Extensional definition)
2. Нарийвчилсан тодорхойлолт (Intensional definition)

3. Хуурмаг тодорхойлолт (Ostensive definition)
4. Нотолсон тодорхойлолт (Demonstrative definition)
5. Үгийн сангийн тодорхойлолт (Lexical definition) зэргээр ангилсан байдаг (Олон улсын стандарт, 2009, х 78).

Нэр томьёо боловсруулах ажилд хуурмаг тодорхойлолтоос бусад тодорхойлолтыг түгээмэл хэрэглэдэг. Үгээр илэрхийлэгдэхгүй хийсвэр объект нь хуурмаг тодорхойлолттой байх боловч ухагдахууныг бүрэн илэрхийлэхгүй юм. Өөрөөр хэлбэл график, схем, зураг зэрэг нь дүрслэл бөгөөд бусад объектоос ялган дүрсэлж, ухагдахууны тодорхойлолтод нэмэлт байдлаар хэрэглэгддэг.

График дүрслэл нь мэргэжлийн болон мэргэжлийн бус хүмүүсд дан ганц бичвэр бүхий тодорхойлолт ойлгомжгүй санагдсан үед ухагдахууныг харагдахуйц төсөөлөлтэй болгодог. Жишээг хүснэгт 1-ээс харна уу.



Энэхүү наран цэцгийн зураг нь “Цэцэг” хэмээх ухагдахууныг дүрслэн үзүүлж байж болох юм. Харин тус ухагдахууныг тодорхойлж чадахгүй. Өөрөөр хэлбэл зүүн талд байгаа энэхүү зураг тухайн объектыг төлөөлж байгаа ч яг тухайн объект өөрөө биш юм. Тиймээс “Цэцэг” хэмээх ухагдахууныг наран цэцэг хэмээх нэгэн зүйлээр нь дүрслэн үзүүлж болохгүй. Үүнийг улам дэлгэрүүлбэл булцуут цэцэг, сараана цэцэг, булцуут хайтан зэрэг болно.

Мэргэжлийн салбар хоорондын нэр томьёог хоорондоо утга ухагдахуун давхцахгүй байхаар нарийвчлан ангилах шаардлагатай байна. Жишээ нь: Канад улсын нэр томьёоны цахим санд “Power supply - эрчим хүчний тэжээл” хэмээх нэр томьёо англи, франц, испани хэл дээр дараах 8 өөр салбарт 8 өөр ухагдахуунаар хэрэглэгдэж байна.

Үүнд:

- Шинжлэх ухааны судалгааны тоног төхөөрөмж-Scientific Research Equipment
- Цахилгааны инженерчлэл-Electrical Engineering
- Цахим зүйл-Electronics
- Механик дамжуулах систем-Mechanical Transmission Systems
- Шуудангийн үйлчилгээний үйл

ажиллагаа-Postal Service Operation

- Шуудангийн марк тэмдэгт-Postage Stamps
- Эд анги-Machinery
- Вакуум Хоолой (цахим зүйл)-Vacuum Tubes (Electronics)

Дээрх 8 салбарын ухагдахуун бүр тодорхойлолт, тайлбар, ишлэл, эх сурвалжаар баталгаажсан байна. Харин монгол хэлэнд “Power supply” хэмээх нэр томьёог “Эрчим хүчний тэжээл” хэмээгээд “Үйлдвэр аж ахуйн газрыг түлш, эрчим хүчний бүх төрлөөр хангах процесс” гэж тайлбар, тодорхойлолт бичиж зураг хавсаргасан байгаа нь нэр томьёог нэг мөр болгох ажилд нэлээд нэмэр болж байгаа юм (Зундуйсүрэн, 2013, х.399). Хүснэгт 2,3-т үндэсний нэр томьёоны стандарт боловсруулах ерөнхий загварыг монгол, англи хэл дээр харууллаа.

Хүснэгт 2.

Цахилгаанжуулалт- Electrification—гэх нэр томъёоны стандарт

Монгол	Англи
<p><b>Цахилгаанжуулалт</b> Холбогдох салбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Цахилгаан эрчим хүчний түгээлт</li> <li>• Электростатик</li> <li>• Эргэлтийн хөрөнгө (Төмөр зам)</li> </ul> <p><b>Тодорхойлолт</b> – Улсын ардын аж ахуй, эдийн засгийн бүх салбар, хүн ам, ахуйн хэрэглээнд цахилгаан төхөөрөмж, хэрэгслийг өргөнөөр нэвтрүүлэх, тэдгээрийг үйлдвэрлэх, ашиглах, цахилгаанаар хангах үйл ажиллагаа.</p> <p><b>Эх сурвалжын тоо:</b> 1 MNS 2919: 2003</p>	<p><b>Electrification</b> Subject Field(s)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Electric Power Distribution</li> <li>• Electrostatics</li> <li>• Rolling Stock (Railroads)</li> </ul> <p><b>OBS</b> – among the first to realize the advantages of -- for tunnel operation were the officials of the Grand Trunk Railway System: -- (...) eliminated the smoke and gases</p> <p><b>Source:</b> United States: data on electrification in America, Europe and Australia / by Arthur J. Manson., New York: Simmons-Boardman, [c1923].</p>

Эх сурвалж: О. Мягмарсүрэн “Үндэсний нэр томъёоны цахим сан 2015”, termiumplus.gc.ca.

Хүснэгт 3

Цахим зүй- Electronics- гэх нэр томъёоны стандарт

Монгол	Англи
<p><b>Цахим зүй</b> Холбогдох салбар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Цахим зүй</li> <li>• Боловсон хүчний удирдлага (ерөнхий)</li> <li>• Холбооны удирдлага</li> </ul> <p><b>Тодорхойлолт</b> Электрон багаж хэрэгсэл (вакумын, хий цахилалтын, хагас дамжуулагчийн)-ийг зохион бүтээх арга зүйн тухай шинжлэх ухаан</p> <p><b>Эх сурвалжын тоо:</b> 1 Зундуйсүрэн.Ч. “Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг”, Уб., 2013, х 391</p>	<p><b>Electronics</b> Subject Field(s)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Electronics</li> <li>• Personnel Management (General)</li> <li>• Federal Administration</li> </ul> <p><b>DEF</b> – branch of science and technology which deals with the study of ... conduction of electricity in a vacuum, a gas, and in semiconductors, and with the utilization of devices based on these phenomena.</p> <p><b>Source:</b> 1 Internet. [<a href="http://europa.eu.int">http://europa.eu.int</a>].</p>

Эх сурвалж: О.Мягмарсүрэн “Үндэсний нэр томъёоны цахим сан 2015”, termiumplus.gc.ca

Хоёрдугаарт: Ухагдахууны талаарх дараах мэдээлэл нэр томъёоны стандартад зайлшгүй орсон байх ёстой. Үүнд:

- **Тодорхойлолт:** Энэ нь ухагдахууны үндсэн утга бүхий шинжүүдийг зааж өгдөг ба бусад ухагдахуунаас ялгадаг.
- **Хам сэдэв:** Тодорхойлолтыг нотлон харуулсан иш татсан бичвэр юм. Тодорхойлох буюу тайлбарлах бичвэрүүд нь ухагдахуунд хамааралтай мэдээллээр хангах үүрэгтэй ба үндсэн болоод туслах шинж чанарууд бүгд ишлэл бичвэрээр илэрч чадахгүй байж болно.
- **Жишээ ба хэлц:** Хэрэглэх жишээнүүд / өгүүлбэрүүд ба хэлцүүд/ нэр томъёонууд дэлгэрүүлсэн үгийн хамт орно. Ухагдахууны талаарх өгөгдсөн мэдээллээс

гадна хэрэглээг харуулдаг.

- **Тэмдэглэл ба тайлбар:** Тэмдэглэл ба тайлбар нь хэрэглээний бодит орчинд үүсэх нэр томъёотой холбоотой нэмэлт мэдээллээр хангаж байдаг.
- **Лавлагаа:** Энэ нь нэр томъёо ба нотлох бичвэрүүдийн эх сурвалжийг зааж өгнө. (Болд, 2009, х.45)

Тэмдэглэгээ, тодорхойлолтын аль аль нь ухагдахууныг илэрхийлдэг ба ухагдахуун, тодорхойлолт, тэмдэглэгээ бүгд нэг объектийн гадаад чанарыг бүрдүүлж байдаг. Тэмдэглэгээ бол ухагдахууныг илэрхийлэх хураангуй дөт арга зам юм. Харин тодорхойлолт нь түүний гадаад чанарыг сонгож ялгах бололцоог бүрдүүлдэг бөгөөд тухайн ухагдахууныг бусад төрөл ухагдахуунаас ялгадаг.

Стандартчилал дахь нэр томьёо боловсруулах ажил нь зөвхөн нэр томьёо ба тэмдэглэгээг стандартчилдаггүй, тодорхойлолтыг бас стандартчилдаг билээ. Байгалийн ухаан, математик, техникийн баримт бичигт тодорхойлолт нь график дүрслэлээс бүрдсэн байж болно. Мөн тодорхойлолт нь томьёогоор илэрхийлэгдсэн, эсвэл томьёоноос бүрдсэн байж болдог.

### Судалгааны үр дүн

1. Ерөнхий хэлний толь бичгүүдэд олон тохиолддог шиг синоним буюу ойролцоо утгыг хэзээ ч тодорхойлолтын оронд хэрэглэдэггүй. Зарим нэр томьёоны санд товчилсон хэлбэрүүдийг нэр томьёо болгон хэрэглэж, тодорхойлолтын оронд товчлоогүй хэлбэрүүдийг бичсэн байдаг ба энэ нь нэр томьёо боловсруулалт биш юм. Товчилсон болон товчлоогүй хэлбэр хоёул тэмдэглэгээ ба нэр томьёоны бичилтийг оруулахдаа нэр томьёо хэмээн авч үзвэл зохино. Бусад хэл дээр ч мөн адил энэ байдлаар авч үзэж болно.
2. Техникт томьёог тодорхойлолт хэмээн үзэж болно.
3. Нэр томьёоны санд ерөнхий хэлний толь бичигт адилхан тодорхойлогдсон үгийн сангийн нэгжүүд ордог хэдий ч тэдгээр нь ухагдахууны системийн нэг хэсгийг бүрдүүлдэг ухагдахууныг тэмдэглэхэд хэрэглэгддэг. Эдгээр толь бичгийг үгийн сангийн нэгжүүдийн талаар лавлахын тулд ашигладаг байна.
4. Ухагдахууны талаарх мэдээллээр хангахын тулд зорилтот хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг авч үзэх хэрэгтэй:
  - Тухайн салбарын ухагдахууны системийг мэддэг, тухайн нэр томьёог өмнө нь хэрэглэж байсан мэргэжлийн хүмүүс
  - Тухайн ухагдахуун болон нэр томьёог харж, хэрэглэж байгаагүй, эсвэл хэрэглэж байсан өөр салбарын мэргэжлийн хүмүүс
  - Тухайн салбарын нэр томьёо болон ухагдахууныг огт харж, хэрэглэж байгаагүй мэргэжлийн бус хүмүүс
5. Зөвхөн тодорхойлолт дангаараа хангалттай бус байж болно. Мэргэжлийн бус хүмүүст зориулан нэр томьёог боловсруулахдаа нэмэлт мэдээлэл, тайлбар, ухагдахууны тодорхойлолт, дэлгэрэнгүй тайлбар, хам сэдэв, нэвтэрхий толь бичгийн мэдээлэл, болон бусад мэдээллийн хэрэгслийг

ашиглах (дүрс, дууны хэсэг гэх мэт) шаардлагатай. Нэр томьёоны толь бичигт байдаг тодорхойлолтыг бичих хэлбэр формат нь хэл хэлэнд өөр байж болно. Хэл бүрийн өөрийн онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй

### ДҮГНЭЛТ

Хэлний үгийн сан, мэдлэгийн сан, шинжлэх ухааны мэдлэгийг баяжуулж буй нэр томьёоны бодлого, төлөвлөлтийг улс орны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх хамгийн үр дүнтэй аргыг илрүүлэн ашиглах хэл, нийгмийн хэрэгцээ шаардлага аль хэдийн бий болжээ. Тухайлбал эрчим хүчний салбарт хамгийн сүүлд 2003 онд “Эрчим хүч ба цахилгаанжуулалт”, нэр томьёо тодорхойлолт, “MNS 2919-2003” хэмээх стандартаас өөр стандарт одоо болтол нэмэгдээгүй байна. Шинэ нэр томьёо үүсгэх, түүнийг тогтоох, стандартчлах байтугай хэрэглэгдэж байгаа нэр томьёогоо цэгцлэх үйл ажиллагааны хурд бодит хэрэгцээнээс хамаагүй хоцорч байна. Гиймээс шинжлэх ухааны салбар бүрт нэр томьёоны толь боловсруулах ажлыг нэг системд оруулан, хамтын өргөн хүрээний бүтээл болгож салбарын эрдэмтэд нээлттэй цахим хэлэлцүүлэг хийж боловсруулан, бидний санал болгож буй үндэсний нэр томьёоны цахим сан үүсгэх загвар стандартын жишгээр жигдлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Анита, Пүүн. (2004). *Language policy of Hong Kong*. Journal of Taiwan Normal University
- Бернард, Сполский. (1998). *Applied sociolinguistics*. Editor Widdowson H. G. Oxford university press.
- Болд, Д. (2009). Шинжлэх ухаан, технологийн нэр томьёоны өгөгдлийн сан байгуулах нь. *ШУТИС-ХБС ЭШ бичиг №2*. Улаанбаатар.
- Гүрбазар, Р. (1996). *Орчуулгын онол дадлагын үндэс*. Улаанбаатар.
- Гэрэлмаа, Г. (2012). *Хэрэглээний хэл шинжлэл*. Улаанбаатар.
- Гэрэлмаа, Г., Шинэбаяр, О. (2014). *Монгол нэр томьёо судлалын товчоо*. Улаанбаатар.
- Дашдаваа, Д. (1977). *Орчуулгын зарим асуудал*. Улаанбаатар.
- Догсүрэн, Ч. (1988). *Монгол нэр томьёо оноох, толилох, жигдлэх асуудалд*. Улаанбаатар.

- Зундуйсүрэн, Ч. (2013). *Шинжлэх ухаан техникийн тайлбартай толь бичиг*. Улаанбаатар.
- Зээнямбуу, Ч. (2014). *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар.
- Клувер, А.Д. (1989). *A manual of terminology*. Human Sciences Research Council. Pretoria
- Монгол улсын стандартын жагсаалт., (2013). *Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв*. Улаанбаатар.
- Монгол улсын үндэсний стандартчиллын тогтолцоо. (2006). *Стандарт хэмжилзүйн үндэсний төв*. MNS1-2:2006. Улаанбаатар
- Мөнхцэцэг, Н., Шинэбаяр, О. (2014). *Монгол нэр томъёо судлал 90*. Улаанбаатар
- Мягмарсүрэн, О. (2015). Хэлний бодлого төлөвлөлтийн хүрээнд техникийн хэлийг боловсронгуй болгох, стандартчилах асуудалд. *МУБИС-НХУС ЭШБ эмхтгэл*, №2. Улаанбаатар.
- Нахир, Моше. (2003). *Micro-corpus codification in the Hebrew Reviva*. No. 5. Department of linguistics. University of Manitoba, Canada.
- Олон улсын стандарт. (2009). *Нэр томъёо боловсруулах ажил- зарчим, арга*. ISO 704:2009. Женев.
- Өнөрбаян, Ц. (2014). Шинжлэх ухаан нэр томъёог журамлах тухай асуудалд. ШУА Хэл зохиолын хүрээлэн. *Нэр томъёо судлалын өгүүллүүд*. Улаанбаатар.
- Равдан, Э. (2013). *Хэрэглээний хэл шинжлэл, хэл сурахуйн онол*. МУИС-ГХСС. Улаанбаатар.
- Хорнбергер, Н.Х. (1994). *Literacy and Language Planning*. Editor Teresa L McCarty. Berlin.
- Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.
- Шинэбаяр, О. (2012). Нэр томъёоны хэм хэмжээ юу, стандарт уу. Нэр томъёо судлал, ШУА Хэл зохиолын хүрээлэн. Улаанбаатар.
- Эрчим хүч ба цахилгаанжуулалт. (2003). Нэр томъёо, тодорхойлолт, Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв. MNS 2919 - 2003. Улаанбаатар
- Cit 05/11/2015, [http:// www. Terminplus.gc.ca](http://www.Terminplus.gc.ca). Public works and government services Canada. 11 Laurier street.
- Cit 15/01/2016, [http://www.iso.org/iso/catalogue detail.htm?csnumber=38109](http://www.iso.org/iso/catalogue_detail.htm?csnumber=38109). *Terminology work, principles and methods*. Geneva. Switzerland.